

БНЭУ-ЫН ОЛОН УЛСЫН НЭР ХҮНД**Д. Пүрэв**

Энэтхэгийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалтын үр дүнд 200-аад жил Энэтхэгт ноёрхож байсан Британийн колонийн дэглэм эгнэгт унаж 1947 оны наймдугаар сарын 15-нд Энэтхэг нь Тусгаар тогтнолоо олж 1950 оны нэгдүгээр сарын 26-нд Бүгд Найрамдах Энэтхэг Улсыг тунхагласан билээ. Тусгаар тогтносон Энэтхэг улсын өмнө колонийн дэглэмээс улиран үлдсэн нийгэм-эдийн засгийн хоцрогдол, үндэстэн ястны хоорондын зөрчил, кастын язгуур угсааны ялгааг арилгах асар том зорилт тулгарсан юм. Улс төр, нийгэм-эдийн засгийн дээрх зорилтыг амьдралд хэрэгжүүлэхэд Энэтхэг улсын анхны Ерөнхий сайд Жавахарлал Неру тэргүүтэй Үндэсний Конгресс нам, түүний засгийн газар чухал үүрэг гүйцэтгэжээ.

Ж. Неругийн толгойлсон үндэсний Конгрессын засгийн газар улс орныг хүнд үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйд газрын шинэчлэлтийн программ хэрэгжүүлэх, соёл шинжлэх ухаан, техник, ардын боловсролыг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгээр эхэлсэн нь Энэтхэгийн улс төрийн тусгаар тогтнолыг бэхжүүлэн улмаар эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилгод нааштай үр дүн үзүүлжээ. Ялангуяа улс ардын аж ахуйг төлөвлөгөөтэй хөгжүүлэх талаар явуулсан бодлого эдийн засгийг капиталийн хараанаас ангижруулахад чухал алхам болжээ.

Улсын салбарын аж ахуйг энэтхэгийн эдийн засагт бэхжүүлэх талаар явуулсан тэмцлийн үрээр Энэтхэг улс үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний хэмжээгээр дэлхийн тэргүүний 10 орны нэгэнд орж байна. Одоо энэтхэгийн аж үйлдвэрт улсын салбарын аж ахуйн байр суурь дорвитой бэхжиж байгаа нь Энэтхэг улс дотоод гадаадын монополийн үйл ажиллагааг таслан зогсоож, эдийн засгийн тусгаар байдлаа бэхжүүлэх гэсэн хүчин чармайлтанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Энэтхэгийн эдийн засгийг хөгжүүлэх 1981-1985 оны VI таван жилийн төлөвлөгөөнд улсын нийт хөрөнгө оруулалтын 60 орчим хувь буюу 694 тэрбум рупийг эдийн засгийн улсын салбарыг хөгжүүлэхэд төлөвлөжээ.

Хөдөө аж ахуйг цахилгаанжуулах усжуулахын зэрэгцээ дотооддоо хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж үйлдвэрлэх болсон нь үр тарианы нөөц хэмжээг өсгөж хүнсний асуудлыг нааштайгаар шийдвэрлэхэд чухал хүчин зүйл болж байна.

Энэтхэг улс тусгаар тогтнолынхоо жилүүдэд шинжлэх ухаан, ардын боловсрол, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн бусад салбарт багагүй амжилт олжээ. Одоогоос 30 гаруйхан жилийн өмнө 100 хүн тутмаас дөнгөж 16 хүн уншиж бичиж чаддаг байсан бол өнөөдөр хүн амын 33 хувь нь бичиг үсэгтэй болжээ. Энэтхэгт одоо 85 сая хүн ямар нэг сургуульд сурч байна.

ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар орчин үеийн аж үйлдвэрийн 70 гаруй барилга байгууламж ашиглалтанд орж энэтхэгийн эдийн засгийн бие даасан хөгжилтөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж эдийн засгийн улсын салбарын ноён нуруу нь болж буйн дотор жилдээ 1,5-2

сая тонн ган гаргах Бхилай, Бокаро, Хардварийн хар төмөрлөгийн үйлдвэр, Ранчийн хүнд машины үйлдвэр, Браун, Койяла, Матхурын нефть боловсруулах үйлдвэр зэрэг багтаж байна.

Энэтхэгийн нийгэм эдийн засгийн эдгээр чухал өөрчлөлтийн үндсэн дээр түүний олон улсын нэр хүнд нэгэн адил дээшилж өнөөдөр БНЭУ олон улсын тавцан дээр өндөр нэр хүндтэй үүрэг гүйцэтгэх болжээ. Түүний олон улсын нэр хүнд ийнхүү өсөн бэхжихэд Энэтхэгийн уламжлалт бодлого болж буй эвсэлд үл нэгдэх бодлого, түүнээс ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, энхийг эрхэмлэгч хүчнүүдтэй тогтоосон найрамдалт харилцаа чухал үүрэг гүйцэтгэж байна. БНЭУ орчин үеийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд нааштай нөлөөлж, олон улсын байдлыг тогтворжуулахад дорвитой хувь нэмэр оруулж ирэв. БНЭУ нь Азийн орнууд, түүний дотор БНХАУ-тай сайн хөршийн харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэж ирэв. Энэтхэгийн засгийн газар 50-иад оны эхээр Солонгос дахь дайны галыг нэн даруй зогсоож энэ орны ард түмэнд хувь заяагаа өөрөө шийдвэрлэх боломж олгохыг империалист харгис хүчнээс удаа дараа шаардаж байсан юм. БНЭУ, Энэтхэг-хятадын хойгийн ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг тууштай дэмжиж ирсэн бөгөөд улс төр, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж байв.

Энэтхэг улс империализм, бээжингийн жанжлалын эсрэг Энэтхэг-хятадын хойгийн ард түмний явуулж байгаа тэмцлийг тууштай дэмжиж БНСВУ, Лаос, Кампучитай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Энэтхэгийн засгийн газар БНКАУ-ын засгийн газрыг албан ёсоор хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон нь Зүүн-Өмнөд Азид энх амгалан, тогтвортой байдлыг тогтоох үйл хэрэгт чухал хүчин зүйл боллоо. Энэтхэгийн засгийн газар Израилын эрх баригчдын Арабын ард түмний эсрэг чиглэсэн булаан эзэлж, эзэгнэх дайнч түрэмгий бодлогыг эрс шийдвэртэй эсэргүүцэж Палестины араб ард түмний шударга тэмцлийг тууштай дэмжиж араб ард түмэнтэй эв санааны бүрэн нэгдэлтэй байна.

Орчин үеийн гол үндсэн асуудлаар Энэтхэгийн засгийн газрын баримталж байгаа оновчтой байр суурь зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах асуудал дээр илэрч байгаа юм. Бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө Энэтхэгийн засгийн газрын явуулж буй бодлого нь Ази болон Энэтхэгийн салбар тивд тогтвортой байдал бий болгоход нааштай үр нөлөө үзүүлж байна. Энэтхэг улс Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгохын төлөө олон жилийн туршид тууштай тэмцэл явуулж ирэв. Энэтхэгийн далайн Диего Гарсия, Чагос арал дээр байгаа америкийн цэргийн баазад цөмийн цэнэгтэй пуужин байрлуулж байгаа АНУ болон империалист гүрнүүдийн цэрэг дайны төлөвлөгөөг таслан зогсоох, Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгох тухай НҮБ-ын 1971 оны шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө Энэтхэг улс тууштай тэмцэж байгаа юм. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг үндэслэгч Энэтхэг улс энх тайван, аюулгүй байдлыг хамтын хүчин чармайлтаар тогтоох, империализм, жанжлал, харгис хүчин, колоничлол, шинэ колоничлол, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогын эсрэг бүх дэвшилтэт хүчний нэгдэл нягтралыг бэхжүүлэх, эрх тэгш шударга ёсны үндсэн дээр олон улсын эдийн засгийн харилцааг өөрчлөн тогтоохын төлөө тууштай тэмцэж байгаа юм. Үүний нэг тодорхой жишээ бол 1981 оны хоёрдугаар сард Энэтхэгийн нийслэл Шинэ Дели хотод хуралдсан, эвсэлд нэгдээгүй орнуудын Гадаад явдлын Яамны Сайд нарын зөвлөлгөөнийг зохион байгуулсан болон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндсэн зарчим зорилго болсон империализм, колоничлол, апартейд бодлого болон сионизмыг оролцуулан арьсны үзэл, гадаадын түрэмгийлэл, жанжлах үзлийн бүх хэлбэр-

рийн эсрэг явуулах тэмцэлд Энэтхэг улс тууштай хандаж чухал хувь нэмэр оруулсаар байна. Энэтхэгийн засгийн газраас Ази тив, олон улсын харилцаанд хэрэгжүүлж байгаа ийм нааштай бодлого, түүний амжилтад хятадын эрх баригчид эрс дургүйцэж олон улсын империализм, харгис хүчинтэй сүлбэлдэж Энэтхэгт даралт шахалт үзүүлэх замаар жанжлах бодлогоо хэрэгжүүлэхийг санаархаж байна.

Энх тайвнаар зэрэгцэн орших зарчимд тулгуурласан Энэтхэг, Зөвлөлтийн найрамдалт харилцаа, үр ашигтай хамтын ажиллагаа цаг үеийн сорилт шалгалтыг даван туулж хоёр их ард түмний язгуур эрх ашигт бүрэн дүүрэн нийцэн хөгжиж ирсэн төдийгүй, Ази даян дэлхийд энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалах, империализм, жанжлах бодлогын эсрэг бүх нийтийн тэмцэлд онцгой үүрэг гүйцэтгэж байна.

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Л. И. Брежнев өнгөрсөн оны эцсээр Энэтхэгт хийсэн айлчлалынхаа үеэр Персийн булан, Энэтхэгийн далайн бүс нутагт олон улсын түгшүүртэй байдлыг намжааж, уг бүс нутгийг энх тайвны бүс болгох тодорхой санал дэвшүүлэн БНЭУ-ын засгийн газар, энэтхэгийн ард түмний зүй ёсны талархлыг хүлээсэн билээ. Империалист харгис хүч, тэдэнтэй цэрэг-стратегийн, улс төрийн талаар ойртон сүлбэлдэж байгаа өнөөдрийн хятадын эрх баригч бүлэг энэ бүс нутагт цэргийн идэвхижилийг улам эрчимжүүлж, уг нутгийн улс гүрний язгуур эрх ашиг, үндэсний бүрэн эрхт байдалд шууд заналхийлж байгаа одоогийн нөхцөлд зөвлөлтийн удирдагчийн энэ санаачилга Энэтхэгийн далай, Персийн буланд бат бэх энх тайвныг тогтоох бүх нийтийн тэмцэлд бас нэг шинэ чухал алхам болов гэж дэлхийн олон нийт үзэж байна. 1955 оны арван нэгдүгээр сард БНМАУ-ын засгийн газар, БНЭУ-тай дипломат харилцаа тогтоосноор дээр үеэс уламжлалт харилцаа бүхий манай хоёр ард түмний харилцааны цоо шинэ үе эхэлсэн юм. Өнгөрсөн 25 жилд тус хоёр орны улс төр, соёл, шинжлэх ухаан, худалдаа эдийн засгийн харилцаа байнга хөгжиж ирэв. 1957 онд БНЭУ-ын Дэд Ерөнхийлөгч агсан д-р Радхакришнан Монголд, 1959, 1973 онд БНМАУ-ын Сайд Нарын Зөвлөлийн даргын хувьд н. Ю. Цэдэнбал Энэтхэгт тус тус айлчилсан нь Монгол Энэтхэгийн харилцааны цаашдын хөгжилтөнд чухал алхам болсон юм.

н. Ю. Цэдэнбалын Энэтхэгт хийсэн 1973 оны айлчлалын үеэр Монгол-энэтхэгийн хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан нь манай хоёр орны найрамдалт харилцаанд томоохон үйл явдал болсон билээ. Дээрх тунхаглалд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох, хүч хэрэглэх буюу хүчээр сүр далайлгахаас татгалзаж, аливаа маргаантай асуудлыг энх тайван, хэлэлцээний замаар зохицуулан шийдвэрлэж байх нийгмийн янз бүрийн байгуулал бүхий улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг хоёр талын болон олон улсын харилцаанд баримталж, Монгол, Энэтхэгийн улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхийг онцлон заасан билээ.

Манай хоёр орны харилцаа дээрх Хамтарсан Тунхаглалын үзэл санааны дагуу амжилттай хөгжиж Ази тивд энх тайван, тогтвортой байдлыг бий болгох, зэвсэглэлийн хойноос хөөцөлдөх явдлыг эцэс болгох, дэлхийн бөмбөрцгийн тодорхой бүс нутгийг цөмийн зэвсэггүй, энхийн бүс болгохын төлөө энхийг эрхэмлэгч бүх хүчний тэмцэлд Монгол, Энэтхэгийн ард түмний хамтын тэмцэл зохих хувь нэмэр оруулсаар байна. Манай хоёр орны соёлын салбар дахь харилцаа идэвхжин хөгжиж байна. Анх 1961 онд байгуулсан соёлын хамтын ажиллагааны Хэлэлцээрийг

1978 онд шинэчилж соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах Хэлэлцээр болгож өргөтгөн байгуулсан нь зохих үр дүнгээ өгч байна.

Энэ хэлэлцээрийн хүрээнд урлагийн хэсэг, кино, төрөл бүрийн үзэсгэлэн, сэтгүүлчид, зохиолчид солилцох зэрэг соёлын харилцааны төрөл бүрийн ажил зохиогдож байгаагийн дээр эрүүлийг хамгаалах, хөдөө аж ахуйн тодорхой салбарт хамтран ажиллах аятай эхлэл тавигдаж, зарим практик алхам хийгдэж байна.

Хоёр орны хооронд анх 1960 онд байгуулагдсан худалдааны хэлэлцээрийг 1978 онд шинэчлэн үсэг зуржээ. Манай хоёр орон газар зүйн хувьд хоорондоо алс хол оршдог зэргээс шалтгаалан зам тээврийн зарим бэрхшээл байдаг ч гэсэн худалдааны харилцаа хөгжиж байна.

Манай хоёр орон ийнхүү хоёр талын болон олон улсын гол чухал асуудлаар адил буюу ойр төсөөтэй байр суурь баримталж, НҮБ, олон улсын бусад байгууллагад хамтран ажиллаж байгаа нь цаашид харилцааг хөгжүүлэх үндэс суурь аятай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

ИНДИЯ И РОСТ ЕЕ МЕЖДУНАРОДНОГО ПРЕСТИЖА

(Резюме)

Д. Пурэв

За годы своего независимого развития республика Индия добилась значительных успехов во всех сферах социально-экономической жизни. Значительно окреп ее авторитет на международной арене. Происшедшие в стране позитивные перемены особенно весомы, если учесть, что колониализм оставил республике тяжелое наследие. Сегодня по объему промышленного производства Индия входит в первую десятку стран несоциалистического мира. Она обеспечивает себя многими важными видами промышленной продукции.

Создание государственного сектора экономики сыграло важную роль в развитии народного хозяйства. Укрепление госсектора Индии шло не только за счет строительства новых современных промышленных объектов, но и в результате таких мер, как национализация банков, страхового дела, крупных предприятий тяжелой и легкой промышленности.

Большие позитивные сдвиги произошли в развитии науки, культуры и образования, здравоохранения и системы социального обеспечения.

В области внешних отношений, проводимая Индией политика неприсоединения, основанная на принципах мирного сосуществования, завоевала широкое международное признание и способствовала укреплению ее авторитета. Правительство Индии активно выступает за осуществление всеобщего и полного разоружения, в том числе за прекращение военных приготовлений империализма в Индийском океане, за обеспечение безопасности в Азии на основе коллективных усилий всех населяющих ее народов.

В ООН и других международных организациях успешно развивается эффективное сотрудничество между Индией, СССР и другими социалистическими странами. Этому в значительной степени способствует совпадение и близость их позиций по коренным проблемам современности.

После установления дипломатических отношений между МНР и Республикой Индия, укрепилась традиционная узы дружбы наших народов. Особую роль в укреплении монголо-индийской дружбы и сотрудничества играют взаимные визиты и деловые встречи руководителей обеих стран. Монголия и Индия неустанно выступают за углубление разрядки в международных отношениях, распространение ее на все районы мира, за всеобщее и полное разоружение, против происков империализма и пекинского гегемонизма в Азии.